



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/26

Улаанбаатар хот

Онцгой амжилт гаргасан багш,
сурагчдыг шагнаж урамшуулах журмыг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Боловсролын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.1, 43.2.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн Багахангай дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 21 дүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд мөрдөгдөж буй “Онцгой амжилт гаргасан багш, сурагчдыг шагнаж урамшуулах журам”-ыг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмыг 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхийг дүүргийн Засаг дарга (А.Сүхболд)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/25, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/20 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны дарга (М.Давааням)-д даалгасугай.

ДАРГА

Ф.МӨНХГЭРЭЛ

Нийслэлийн Багахангай дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2023 оны 07 сарын 07-ны өдрийн
А/26 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

ОНЦГОЙ АМЖИЛТ ГАРГАСАН БАГШ, СУРАГЧДЫГ ШАГНАЖ УРАМШУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Боловсролын талаар төрөөс баримтлах бодлого, шийдвэр, Монгол Улсын Засгийн газар, Нийслэл, дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, өсвөр залуу үеийг сурган хүмүүжүүлэх үйл хэрэгт идэвх зүтгэл гарган, үр бүтээлтэй ажиллаж, онцгой амжилт гаргасан багш, сурган хүмүүжүүлэгч, хамт олон, сурлага, урлаг, спортын өндөр амжилт үзүүлсэн сурагч, хүүхдийг шагнаж урамшуулахад энэхүү журмыг мөрдөнө.

Хоёр. Шагналын хамрах хүрээ

2.1 Олон улс, улс, нийслэлийн олимпиад, уралдаан, тэмцээнд өөрөө буюу бэлтгэсэн шавь нар нь оролцож эхний 1-3 дугаар байр эзэлсэн багш, сурган хүмүүжүүлэгч

2.2 Олон улс, улс, нийслэлийн олимпиад, уралдаан, тэмцээнд оролцож эхний 1-3 дугаар байрт шалгарсан сурагч, хүүхэд

2.3 Олон улс, улс, нийслэлийн олимпиад, уралдаан, тэмцээнд оролцож эхний 1-3 дугаар байрт шалгарсан баг, хамт олон

2.4 Элсэлтийн ерөнхий шалгалтад 650-аас дээш дундаж оноо авсан сурагч, нэг хичээл нь 700-аас дээш оноо авсан сурагч, бэлтгэн оролцуулсан багш, хэмжээст онооны дундаж 500-аас дээш шалгагдсан багш

Гурав. Шагналд тодорхойлох, бүрдүүлэх материал

3.1 Шагналд нэр дэвшигч нь журмын шалгуурыг хангасан байна.

3.2 Шагнуулахаар нэр дэвшүүлсэн хүмүүсийг тодорхойлохдоо дор дурдсан материалыг бүрдүүлэн үндсэн байгууллагын албан тоотоор баталгаажуулж ирүүлнэ. Үүнд:

а/Ажил байдлын тодорхойлолт

б/Элсэлтийн ерөнхий шалгалтын болон, шагналын батламжийн хуулбар

3.3 Шагнагдагсдын ажил байдлын тодорхойлолтод ажлын амжилт, туршлага, авьяас чадвар, оруулсан хувь нэмрийг үнэн зөв, тодорхой бичиж үндсэн байгууллагын дарга, захирал, эрхлэгч гарын үсэг зурж баталгаажуулна.

3.4 Шагналын материалыг ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтэс хянан үзэж ИТХ, Засаг даргын зөвлөлийн хамтарсан хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр уламжилна.

Дөрөв. Шагналын сан

4.1 Энэхүү шагналын дагалдах мөнгөн шагналыг орон нутгийн төсвөөс олгоно.

Тав. Шагнал

5.1 Олон улс, улс, нийслэлийн олимпиад, уралдаан тэмцээнд оролцож 1-3 дугаар байр эзэлсэн, элсэлтийн ерөнхий шалгалт өгсөн судлагдахуунуудын дундаж оноо нь 650-аас дээш сурагч, нэг хичээл нь 700-аас дээш оноо авч амжилт гаргасан багш, сурагчдад амжилт тус бүрээр, тухайн судлагдахуунаар шалгагдсан нийт сурагчдын дундаж нь 500-аас дээш хэмжээст оноотой багш нарт дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын хамтарсан Өргөмжлөл хүртээх бөгөөд мөнгөн шагналыг дараах байдлаар олгоно.

Мөнгөн шагналын хэмжээ, төг

№	Шагналын номинаци		Байр	Олон улс	Монгол улс	Нийслэл
1	Багш	Бие дааж оролцсон	I	1,000,000	800,000	600,000
			II	800,000	600,000	400,000
			III	600,000	400,000	200,000
		Сурагч бэлтгэсэн	I	800,000	600,000	400,000
			II	600,000	400,000	200,000
			III	300,000	200,000	100,000
2	Сурагч, хүүхэд	Ганцаарчилсан	I	300,000	200,000	100,000
			II	200,000	100,000	80,000
			III	100,000	80,000	50,000
		Баг хамт олон	I	400,000	250,000	150,000
			II	250,000	150,000	100,000
			III	150,000	100,000	80,000
3.	ЭЕШ	Сурагч	200,000			
		Бэлтгэсэн багш	200,000			
		Хэмжээст онооны дундаж 500-аас дээш шалгагдсан багш	200,000			

5.2 Багш, сурагчдад олгосон мөнгөн шагналын 10 хувийг хүн амын орлогын албан татварт суутгаж тооцно.

5.3 ЕБС-ийн сурлагын амжилт, чанарыг дээшлүүлэх, элсэлтийн ерөнхий шалгалтын дүүргийн дундаж оноог Нийслэлийн түвшинд хүргэхэд хяналт тавьж, үр дүнг тайлагнахыг Боловсролын хэлтэс хариуцан зохион байгуулна.

Зургаа. Тайлбар

6.1 Олон улсын хэмжээнд гэдэгт: Монгол улсын Засгийн газрын холбогдох, тогтоол, журмын дагуу Дэлхий, тив, бүс орон нутгийн орнуудыг хамарсан олимпиад, уралдаан тэмцээн

6.2 Монгол улсын хэмжээнд гэдэгт: Төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр, удирдамж, заавар журмаар зохион байгуулагдаж байгаа төрөлжсөн олимпиад, соёл урлаг, спортын уралдаан тэмцээн

6.3 Нийслэлийн хэмжээнд гэдэгт: Нийслэлийн төрийн захиргааны байгууллагын шийдвэр, удирдамж, заавар, журмын дагуу зохион байгуулагдсан төрөлжсөн олимпиад, урлаг, спортын уралдаан тэмцээн гэж тус тус ойлгоно

6.4 Энэхүү журмын үйлчлэх хүрээ : 'Дүүрэгт суралцаж, ажиллаж байгаа багш, сурагч, хүүхдэд хамаарна.